

2470



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ө.ЭНХТӨР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 24 № 3/541
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цагдаагийн ерөнхий газрын даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит



www.audit.mn

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

УАГ-ын Санхүүгийн аудитын
газрын дарга Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261740
Цахим хаяг:
guniidmaa@audit.gov.mn

Шинжээч : Д.Цэгмиддорж
Утас: 261740
tsegmiddorid@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

АГУУЛГА

1.	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2.	Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4.	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5.	Дотоод хяналт.....	4
6.	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	5
7.	Шилэн дансны мэдээлэл.....	5
8.	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	5
9.	Гол, онцлог гүйлгээний талаар.....	5
10.	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	6
11.	Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	7
12.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
13.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
14.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
15.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
16.	Зөвлөмж	8
17.	Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт	8

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд /САГ-2017/9/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 3 дугаар сарын 5-наас 2017 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ахлах аудитор Ж.Батсайхан, аудитор Ш.Отгонбаяр, шинжээч Д.Цэгмиддорж нар хэрэгжүүлж ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Тус байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хүрээнд ажиллаж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2016 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээ болон удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах, байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Цагдаагийн байгууллагаас 2016 онд нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд анхаарал хандуулж, төр, захиргаа, хууль хяналт, төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй хамтран ажилласны үр дүнд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт 2.1 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт өссөн үзүүлэлттэй байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Цагдаагийн ерөнхий газрын нэгтгэсэн тайланд, 61 төсвийн байгууллага, 2 аж ахуйн нэгжийн тайлан нэгтгэгдсэн байна. Аудитаар 46 байгууллагт санхүүгийн тайлангийн аудит хийж дүгнэлт гаргасан, 16 байгууллагын санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан байна. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Техник засварын төв нууцын зэрэглэлтэй учир аудитад хамрагдаагүй байна. Нийт батлагдсан төсвийн 36.0 хувьд нь Үндэсний аудитын газар, 58.0 хувьд нь Аймаг, нийслэлийн аудитын газар аудит хийсэн байна. Нууцын зэрэглэлтэй Техник засварын төв нь нийт батлагдсан төсвийн 6.0 хувийг эзэлж байна.

Салбар, нэгжийн 41 байгууллага нь “Зөрчилгүй” санал дүгнэлт, “Монгол тамга” ТӨҮГ нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт авч, 16 байгууллага санхүүгийн тайланд аудитын түүвэрт хамрагдсан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/72 дугаар тушаалаар “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шаардлагыг хангаж байгаа 4 байгууллагад Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасны дагуу 2016 оны санхүүгийн тайланд нь итгэл үзүүлсэн байна.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 5 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 3,730.4 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг "Acolous" програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Дотоод хяналтын талаар

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ЦЕГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 9,851.90 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,759.0 сая төгрөг төвлөрч 1,092.9 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ. Нэр бүхий 25 байгууллага 1,233.5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна. Үүнд дараах хүчин зүйл голлон нөлөөлсөн байна.

- Уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэр" ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын хамгаалалтанд байдаг. Гэтэл гэрээт цагдаагийн хэлтсийн цалингаас бусад зардлыг "Эрдэнэт үйлдвэр" ХХК шууд олгож байгаа тул орлого 492,2 сая төгрөгөөр тасалдсан буюу нийт тасарсан орлогын 45.0 хувийг эзэлж байна.
- Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн төв байр, радио телевизийн эфирийн студи нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолоор цагдаагийн гэрээт хамгаалалтанд байдаг. Дээрх тогтоолыг 2015 оны 19 дүгээр тогтоолоор өөрчилж хамгаалалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг болсон тул 328.2 сая төгрөгөөр орлого тасалдсан буюу нийт тасарсан орлогын 30.0 хувийг эзэлж байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 235 дугаар тогтоолоор Монгол банкны төв байрыг цагдаагийн гэрээт хамгаалалтанд байхаар заасан 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Н-0216/311 дугаар гэрээний дагуу санхүүжилтаа бүрэн олгоогүйгээс 248.0 сая төгрөгөөр тасалдсан буюу нийт тасарсан орлогын 27.7 хувийг эзэлж байна.

- Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх баривчлах байр нь архидан согтуурсан иргэдийг саатуулдаг байсан. Дээрх чиг үүрэг нь Эрүүл мэндийн яаманд шилжсэнээр зөвхөн зөрчил гаргасан иргэдийг саатуулах байранд саатуулж, архидан согтуурсан иргэдийг эмнэлгийн байгуулагад хүргэх болсноор төсвийн орлого тасрах шалтгаан болсон байна.

Долоо. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2016 онд Шилэн дансны нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn>, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажиллаж байна. Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас 2016 оны 12 дугаар сард хийсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн аудитаар зөрчилгүй гарсан байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаар

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бусад орлого, тэтгэлэг, хувьсах зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Наадмын хамгаалалтын 268.6 сая төгрөгийн зардлын төсвөөс, гүйцэтгэлээр 268.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг нийт 241 албан хаагчдад 5,931.8 сая төгрөгийг олгосон байна. УИХ болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 361.6 сая төгрөгийн төсөв батлагдснаас, гүйцэтгэлээр 360.8 сая төгрөгийг зарцуулсан буюу 0.2 хувиар хэмнэсэн, мөн сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 293.1 сая төгрөгийн төсөв батлагдснаас, гүйцэтгэлээр 285.4 сая төгрөгийг зарцуулсан буюу 2.6 хувиар хэмнэсэн байна. Дээрх сонгуулиудын зардлаас хэмнэсэн нийт 8.5 сая төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлалын нэгтгэсэн тайланг бэлтгэсэн эсэхийг нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 654.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 128.7 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Дээрх хөрөнгийн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах,

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, мөн хуулийн 31.2-т Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2. ЦЕГ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Монгол тамга” ТӨҮГ, “Цагаан шонхор” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Гэтэл дээрх 2 байгууллагын үйл ажиллагаанд хяналт, тавих удирдлагыг томилох эрх нь Төрийн өмчийн хороонд байгаа бөгөөд ЦЕГ-т хамааралгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал эдгээр 2 ААН-ийн удирдлагыг Төрийн өмчийн хорооноос томилсон бөгөөд үйл ажиллагааны чиг үүрэг Цагдаагийн албаны тухай хууль болон Хууль зүйн сайдын 2014 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, ЦЕГ-ын чиг үүрэгт байхгүй байна. Иймд дээрх 2 ААН-ийн чиг үүрэг, удирдлага, хяналтын үйл ажиллагааг ЦЕГ-т хамаарах эсэхийг эцэслэн шийдвэрлэж, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно” гэсэн заалтыг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах байгууллага, нэгжийн жагсаалт гаргаж баталгаажуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно” гэсэн заалтыг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах байгууллага, нэгжийн жагсаалт гаргаж баталгаажуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3. Тус байгууллагын малын данс бүртгэлд нийт 489.3 сая төгрөгийн мал бүртгэлтэй байгаа ба нэг төрлийн малын дансны үнэ өөр өөр байна. Энэ нь ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Малын анхны өртгийг бодитоор тооцож, зах зээлийн ханш, болон үнийн өөрчлөлттэй холбогдуулан данс бүртгэлд тусгаж байх. ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т “Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулах” гэж заасныг мөрдөж ажиллах.

4. Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 9,851.90 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,759.0 сая төгрөг буюу 1,092.9 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ. Нэр бүхий 25 байгууллага 1,233.5

сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, гэж заасны дагуу орлогыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөж төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

5. Төсвийн шууд захирагчдын аудитаар 36 асуудлаар 2,197.4 сая төгрөгийн залруулга, 58 асуудлаар 508.5 сая төгрөгийн зөвлөмж, 39 асуудлаар 423.4 сая төгрөгийн албан шаардлага, 10 асуудлаар 7.6 сая төгрөгийн төлбөрийн акт тус тус өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэсний аудитын газар болон Аймаг, нийслэлийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх, төлбөрийн актыг барагдуулах талаар анхаарч ажиллах.

“Монгол тамга” ТӨҮГ-ын 2016 оны аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд:

- Монгол тамга ТӨҮГ-ын удирдлага өөртөө тушаал гаргаж цалингийн урьдчилгаанд 4.1 сая төгрөг, орон сууцны зээл төлөхөд 6.1 сая төгрөг, хүүхдийн сургалтын төлбөрт 1.0 сая төгрөг, 17.2 сая төгрөгийн үнэ бүхий 2800 м.кв газрыг өөрийн эзэмшилд шилжүүлж авлагаар бүртгэсэн, мөн нягтлан бодогчийн хүүхдийн сургалтын төлбөрт 2.0 сая төгрөг олгосон зэрэг нийт 30.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.
- Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 129.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасанд албан шаардлага өгсөн байна.
- Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо унаа хоолны мөнгө 3.2 сая төгрөгийг дундаж цалинд оруулж тооцсонд албан шаардлага өгсөн байна.
- Аудитаар нийт 176.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн байна.
- Мөн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 67.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 186.2 сая төгрөгийн 5 зөвлөмжийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Цагаан шонхор” ТӨААТҮГ-ын 2016 оны аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд:

- Аудитын явцад орлого нэмэгдүүлэх бичилт хийсэн 26.8 сая төгрөг, бусад татварын өглөг болон бусад татварын зардлыг дутуу бүртгэсэн 0.9 сая төгрөг, ХХОАТ-ыг илүү тайлагнасан 5.1 сая төгрөг, нийт 32.8 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар 4 зөвлөмж өгсөн байна.

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Цагдаагийн ерөнхий гарзын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6,049.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад залруулсан 2,230.2 сая төгрөг, материаллаг бус алдаа 1,306.6 сая төгрөг, материаллаг алдаа 2,512.9 сая төгрөг байна. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 6 зөвлөмж өгсөн болно.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ҮАГ-аас 3 зөвлөмж өгсөн байна. Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Арван зургаа. Зөвлөмж

2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 6 зөвлөмж өгч байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1, 2, 3, 4, 5, 6 зүйлс:

Асуудал 1

Үндсэн хөрөнгийн талаархуудас 3

Асуудал 2

Бараа материалын талаархуудас 4

Асуудал 3

Орлогын талаархуудас 5

Асуудал 4

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн
талаар.....хуудас 6

Асуудал 5

Нэгтгэсэн тайлангийн талаархуудас 7

Асуудал 6

Монгол тамга ТӨҮГ-ын талаархуудас 8

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээрх зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээрх зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол № 1

ҮАГ-ын ажиглалт

Цагдаагийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 654.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 162.9 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Дээрх үндсэн хөрөнгө, бараа материалын талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах,

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, мөн хуулийн 31.2-т Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэн

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын малын данс бүртгэлд нийт 489.3 сая төгрөгийн мал бүртгэлтэй байгаа ба нэг төрлийн малын дансны үнэ өөр өөр байна. Энэ нь ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Малын анхны өртгийг бодитоор тооцож, зах зээлийн ханш, болон үнийн өөрчлөлттэй холбогдуулан данс бүртгэлд тусгаж байх. ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын даргын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т “Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулах” гэж заасныг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд бараа материал үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглал шамшигдал үүсэх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 9,851.90 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,759.0 сая төгрөг буюу 1,092.9 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ. Нэр бүхий 25 байгууллага 1,233.5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, орлогыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөж төлөвлөгөөг бүрэн биелүүлэх,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Орлогыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн шууд захирагчдын аудитаар 36 асуудлаар 2,197.4 сая төгрөгийн залруулга, 58 асуудлаар 508.5 сая төгрөгийн зөвлөмж, 39 асуудлаар 423.4 сая төгрөгийн албан шаардлага, 10 асуудлаар 7.6 сая төгрөгийн төлбөрийн акт тус тус тогтоосон байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Үндэсний аудитын газар болон Аймаг, нийслэлийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх, төлбөрийн актыг барагдуулах талаар анхаарч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглал шамшигдал үүсэх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

ЦЕГ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Монгол тамга” ТӨҮГ, “Цагаан шонхор” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Гэтэл дээрх 2 байгууллагын үйл ажиллагаанд хяналт, тавих удирдлагыг томилох эрх нь Төрийн өмчийн хороонд байгаа бөгөөд ЦЕГ-т хамааралгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал эдгээр 2 ААН-ийн удирдлагыг Төрийн өмчийн хорооноос томилсон бөгөөд үйл ажиллагааны чиг үүрэг Цагдаагийн албаны тухай хууль болон Хууль зүйн сайдын 2014 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, ЦЕГ-ын чиг үүрэгт байхгүй байна. Иймд дээрх 2 ААН-ийн чиг үүрэг, удирдлага, хяналтын үйл ажиллагааг ЦЕГ-т хамаарах эсэхийг эцэслэн шийдвэрлэж, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно” гэсэн заалтыг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах байгууллага, нэгжийн жагсаалт гаргаж баталгаажуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Эрсдэлүүд

Цагдаагийн ерөнхий газраас чиг үүрэг, үйл ажиллагаанд хяналт тавьж байх,

ҮАГ-ын зөвлөмжүүд

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно” гэсэн заалтыг үндэслэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах байгууллага, нэгжийн жагсаалт гаргаж баталгаажуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

ҮАГ-ын ажиглалт

Монгол тамга ТӨҮГ-ын удирдлага өөртөө тушаал гаргаж цалингийн урьдчилгаанд 4.1 сая төгрөг, орон сууцны зээл төлөхөд 6.1 сая төгрөг, хүүхдийн сургалтын төлбөрт 1.0 сая төгрөг, 17.2 сая төгрөгийн үнэ бүхий 2800 м.кв газрыг өөрийн эзэмшилд шилжүүлж авлагаар бүртгэсэн, мөн нягтлан бодогчийн хүүхдийн сургалтын төлбөрт 2.0 сая төгрөг олгосон зэрэг нийт 30.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 129.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо унаа хоолны мөнгө 3.2 сая төгрөгийг дундаж цалинд оруулж тооцсон зэрэгт тус тус албан шаардлага өгсөн байна.

Аудитаар нийт 176.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн байна.

Эрсдэлүүд

Цагдаагийн ерөнхий газраас чиг үүрэг, үйл ажиллагаанд хяналт тавьж байх,

ҮАГ-ын зөвлөмжүүд

- НӨАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4,
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох” журмын 4,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т заасныг тус тус заасныг зөрчсөн байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 5-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.